

2014

# МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ



## Мэдээ-6

Мэдээний агуулга

- Тэтгэлэгт хэн хамрагдах вэ ?
- Тэтгэлэгт тавигдах шаардлага юу вэ ?
- Бүртгэл, шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулдаг вэ?
- Муис-ийн оюутанд зориулсан тэтгэлэг
- 2013-2014 оны хичээлийн жилд муис-ийн оюутнуудад олгогдсон тэтгэлэг



**МУИС-ИЙН ОЮУТАНД ОЛГОГДДОГ ТЭТГЭЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА**ТЭТГЭЛЭГТ ХЭН ХАМРАГДАХ ВЭ ? Тэтгэлэгийн зорилго:

Монгол улсын их сургуульд суралцаж буй оюунлаг, авъяаслаг, тэргүүний оюутнууд, түүнчлэн амжилттай суралцаж байгаа хэдий ч амьдарлын боломж муутай суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сурах үйлсийг дэмжих зорилготой гадаад дотоодын хувь хүн, байгууллагын 10 орчим тэтгэлэгт хамрагдах боломжтой.

ТЭТГЭЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА ЮУ ВЭ ?

Тэтгэлэгийн зорилго, хамрах хүрээнээс шалтгаалан тэтгэлэгт тавигдах шаардлага өөр өөр байх боловч нийтлэг хэд хэдэн шаардлага байна. Үүнд:

1. МУИС-д амжилттай суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний өдрийн ангийн оюутан байх
2. Сурлагын үнэлгээний голч дүн /GPA/- 3.0 дээш голчтой байх
3. Оюутан нь давхар тэтгэлэгт хамрагдаагүй байх
4. Оюутан нь МУИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдож байгаа эрдэм шинэжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад амжилттай оролцож эхний 3 байранд шалгарсан бол, мөн сайн дурын мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцон, нийгэмд үнэлэгдэхүйц байдлыг үнэлэн тэтгэлэг олгоно.

БҮРТГЭЛ, ШАЛГАРУУЛАЛТЫГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛДАГ ВЭ?

Тэтгэлэгийн зарыг МУИС-ийн вебсайт [www.num.edu.mn](http://www.num.edu.mn), фэйсбүүк [www.facebook.com/MUIS.OYT/](https://www.facebook.com/MUIS.OYT/) хаягаар нээлттэй хүргэдэг бөгөөд оюутнууд тухайн тэтгэлэгийн шаардлагад нийцэж байвал сонгон шалгаруулалтад оролцох нь мөн нээлттэй байдаг.

СНА-ны ажлын Оюутанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд зарлагдсан тэтгэлэгийн шаардлагын дагуу суралцагчийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч, хянан баталгаажуулж холбогдох газарт хүргүүлнэ.

Тэтгэлэгийн сонгон шалгаруулалтыг тэтгэлэг зарлаж буй байгууллага, сан нь өөрсдийн шаардлагад нийцүүлэн жил бүр тодорхой тооны оюутанд шинээр буюу үргэлжлүүлэн тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэж, сонгон шалгаруулалтын эцсийн дүнг МУИС-д ирүүлнэ. Сургуулийн зүгээс тухайн зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрийн зар, мэдээллийг түгээх, сонгогдсон оюутнуудад тэтгэлэгийг түгээхтэй холбоотой бичиг баримтын зохицуулалт, гардуулах болон түүнтэй холбоотой ёслолын үйл ажиллагааг зохион байгуулдаг.

**МУИС-ИЙН ОЮУТАНД ЗОРИУЛСАН ТЭТГЭЛЭГ**

	<b>Тэтгэлэгийн нэр</b>	<b>Тэтгэлэгийн зорилго, болзол</b>	<b>Бүрдүүлэх материал</b>	<b>Зарлагдах хугацаа /жил бүр/</b>
1.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	Сурлага, урлаг, спортын онцгой амжилт үзүүлсэн тэргүүний суралцагчийг дэмжих /ЗГ-ын 2008 оны 46 тогтоол, журмын дагуу/	Албан ёсны дүнгийн тодорхойлолт сургуулийн тодорхойлолт өргөдлийн маягт амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар, наториатаар баталгаажуулах	6 сар

2.	МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг	Улсын олимпиадад 1-3 байр эзлэн МУИС-д элссэн оюутнууд, онцгой амжилт гаргасан оюутнуудыг дэмжих	Албан ёсны дүнгийн тодорхойлолт /2, түүнээс дээш түвшинд хамаарна/ анкет Бусад	5 сар
3.	Япон улсын "Сумитомо" корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Азийн хөгжиж буй улс орнуудын ирээдүйн лидер болох шилдэг оюутнуудыг дэмжих 1-р түвшний суралцагч байх	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар бусад	2 сар
4.	Япон улсын Мицубиши Корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай бакалавр, магистр, докторын түвшний суралцагч	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Бичиг баримтын хуулбар Бусад	10 сар
5.	БНСУ-ын "POSCO ASIA FELLOWSHIP"-ийн тэтгэлэг	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч 2-р түвшний суралцагч байх	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар Бусад	2 сар
6.	Тайваны Монгол-Төвдийн хорооны тэтгэлэгт	Сурлага сайтай нийгмийн идэвхи, оролцоо сайтай магистр, доктор, бакалаврын түвшний суралцагч /хятад хэл суралцагчийг дэмжинэ/	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Бичиг баримтын хуулбар Бусад	2, 9 сар
7.	Тайваний иргэн Өнө Уртагийн тэтгэлэг	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч	Суралцсан хугацааны албан ёсны дүнгийн тодорхойлолт өргөдлийн маягт амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар	5 сар
8.	"Монгол-Намьянжу боловсролыг дэмжих сан"-ийн тэтгэлэг	Солонгос хэл судалж байгаа сурлага сайтай, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар бусад	4, 9 сар
9.	БНСУ-ын Жан Жон Соны нэрэмжит тэтгэлэг	Сурлага сайтай, амьдарлын боломж муутай суралцагч	Албан ёсны дүнгийн тодорхойлолт Анкет Амжилтыг гэрчлэх бичиг баримтын хуулбар, бусад	6 сар

**2013-2014 оны хичээлийн жилд МУИС-ийн оюутнуудад олгогдсон тэтгэлэг**

	<b>Тэтгэлэг олгож буй байгууллага</b>	<b>Тоо</b>	<b>Тэтгэлэгийн хэмжээ</b>	<b>Тэтгэлэг олгох болзол</b>
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	7	1000 000₮	Онцгой авьяас, чадварыг хөгжүүлэх, урамшуулан дэмжих зорилгоор сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчид
2.	МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг	30	Сургалтын төлбөрийн 50-100%	Улсын хэмжээний олимпиадын 1-3-р байранд орсон МУИС-д элсэгч, суралцагсдад олгодог
3.	Азийн сан, Ширин Панжу, “Зориг сан”-гийн тэтгэлэг	52	500 000₮	Сурлагаар тэргүүний, нийгмийн идэвхи, оролцоо сайтай суралцагч
4.	Швейцарийн хөгжлийн агентлаг “Оюутны сургалтын тэтгэлэг”	13	500\$	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч
5.	LG International корпорацийн хамтарсан тэтгэлэг	4	Сургалтын төлбөр	Геологи, уул уурхайн чиглэлээр сайн суралцаж буй сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэлтэй байгаа оюутнууд
6.	Тайваний иргэн Өнө Уртагийн тэтгэлэг	6	500\$	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч
7.	“Сумитомо” корпорацийн нэрэмжит тэтгэлэг	30	800000₮	Азийн хөгжиж буй улс орнуудын ирээдүйн лидер болох шилдэг оюутнуудыг дэмжих /амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч 1-р түвшний суралцагч байх/
8.	Мицубиши корпорацийн нэрэмжит тэтгэлэг	15	520000₮	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай, бакалавр, магистр, докторын түвшний оюутнууд байх
9.	БНСУ-ын “POSCO ASIA FELLOWSHIP”-ийн тэтгэлэг	15	700\$	Сурлагын үзүүлэлт, нийгмийн идэвхи, гаргасан амжилтыг үндэслэнэ
10.	ХААН Банкны Нэрэмжит Тэтгэлэг	15	500 000₮	Өндөр амжилттай суралцаж байгаа тэргүүний оюутан залуусыг дэмжих
11.	БНСУ-ын Дунг-Ин Форум, Гаүли ХХК-ийн нэрэмжит тэтгэлэг	5	Сургалтын төлбөр	Сурлага сайтай, амьдарлын бололцоо муутай, хагас, бүтэн өнчин 1-3 ангийн оюутнууд
	<b>Нийт</b>	<b>192</b>		

Мэдээллийг бэлтгэсэн,

Б.Энхжаргал

ОУ, СНА